

ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?



"Итгэлцлийн үйлчилгээ" гэж харилцан тохиролцож байгуулсан хөрөнгө итгэмжлэх гэрээнд заасан хугацаанд итгэмжлүүлсэн хөрөнгийг үнэгүйдлээс хамгаалж, түүнийг удирдан үр шим хүртэх боломж олгох үйл ажиллагаа юм.



Итгэмжлэгч:

Хөрөнгөө захиран зарцуулах эрхээ гэрээний үндсэн дээр бусдад шилжүүлэн түүнээсээ үр шимийг хүртэгч



Итгэлцлийн

эрхлэгч:

Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд.



Итгэмжлэгч өөрийн хөрөнгийг итгэлцлийн үйлчилгээ эрхлэгчийн өмчлөлд 6 сараас доошгүй байршуулна.



Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй эсэхийг шалгаарай.



2024 оны 1-р улирлын байдлаар санхүүгийн зохицуулах хорооноос уг үйлчилгээ эрхлэх зөвшөөрөлтэй **80** ББСБ үйл ажиллагаа эрхэлж байна.

ИТГЭЛЦЛИЙН ХӨРӨНГӨ НЬ ЯМАР ТӨРӨЛ ХЭЛБЭРТЭЙ БАЙЖ БОЛОХ ВЭ?



Мөнгөн хөрөнгө



Үнэт цаас:
Бонд, Хувьцаа
гэх мэт



Сангийн хөрөнгө



Үл хөдлөх хөрөнгө



Тухайн ББСБ нь харилцагчдыг өөрийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн загвар, нөөц боломжоос хамаарч итгэлцлийн хөрөнгөө ямар хэлбэрээр авах мэдээлэл, нөхцөлөөр хангана.

Итгэмжлэгч нь итгэмжлүүлсэн хөрөнгөө өвлүүлэх, бэлэглэх, захиран зарцуулах зэргээр эрхээ шилжүүлэх боломжтой.

ӨГӨӨЖИЙН ТҮВШИНГ ХАРЬЦУУЛСНААР ХАРВАЛ



Итгэлцлийн үйлчилгээнд юуг анхаарах вэ?

- Итгэлцлийн үйлчилгээ үзүүлэх эрхтэй эсэх.
- Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан итгэлцлийн үйлчилгээний журамтай танилцах.
- Эрсдэлийг итгэмжлэгч өөрөө хариуцахыг анхаарах.
- Харилцан тохиролцож, хөрөнгө итгэмжлэх гэрээг байгуулах.
- Итгэлцлийн үйлчилгээтэй холбогдох гомдлыг санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдэх.



Итгэлцлийн үйлчилгээний
журамтай танилцах

